

**“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН 2009 ОНЫ  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

**Дархан Уул аймаг  
2010 он**

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ**  
**“ ДАРХАН ТЭЭВЭР ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН**  
**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

20.10. оны 03. сарын 21.-ны өдөр

Дугаар 01

Дархан сум

**Хувь нийлүүлэгчдийн ээлжит  
хурлыг хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.3, 61-р зүйл, “Дархан тээвэр” ХК-ийн дүрмийн 10.1-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралдааныг ” Монгол алт ” ХК-ийн хурлын танхимд 2010 оны 04 сарын 26-ны өдрийн 13 цагт хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувь нийлүүлэгчдийн хурлаар
  - Компанийн 2009 оны санхүүгийн тайлан
  - ТУЗ-ийн тайлан
  - ХШЗ-ийн тайлан
  - Ногдол ашиг тараах
  - Компаний нэрийг өөрчлөн “Алтан Сагс”ХК болгох тухай асуудлыг батлуулсугай.
3. Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрх бүхий гишүүдийн бүртгэлийг 2010 оны 03 сарын 30-ний өдөр зохион байгуулж, хувь нийлүүлэгчдэд өнгөрсөн жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг танилцуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
4. Бүртгэх сүүлчийн өдрийг 2010 оны 04 сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай энэхүү шийдвэрийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ХК-д 2010 оны 03 сарын 24-ны дотор тус тус хүргүүлж, хувь нийлүүлэгчдэд 2010 оны 03 сарын 25-ны өдрөөс эхлэн мэдэгдэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА



Ж.ОЧИРСҮХ

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ**  
**“ ДАРХАН ТЭЭВЭР ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН**  
**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2010 оны 03 сарын 21-ны өдөр

Дугаар 02

Дархан сум

**Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал зохион  
байгуулах комисс томилох тухай**

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах хорооны 2008 оны 06 сарын 12-ны “ Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэх тухай ” журмын 3.4.6, ТУЗ-ийн 2010 оны 03 сарын 21-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компаний 2010 оны хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дарга Ж.Очирсүх, гишүүн Ж.Мягмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

2. Хувь нийлүүлэгчдэд танилцуулах материалын жагсаалтыг гаргаж, бэлтгэх ажлыг 2010 оны 03 сарын 30-ны дотор бэлэн болгохыг зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

3. Материалыг 2010 оны 03 сарын 30-ны өдрөөс 04 сарын 23 хүртэл “ Монгол алт ” ХК-ийн байранд хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдэд танилцуулахыг зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

4. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга: Ж.Мягмаа

Э.Золзаяа

5. “ Компанийн тухай “ хуулийн 68-р зүйл, компанийн дүрмийн 9.13-р заалтыг мөрдөн ажиллахыг тооллогын комиссын дарга Б.Цогзолмаад үүрэг болгосугай

6. Тооллогын комиссоор ажиллах Ж.Мягмаа, Э.Золзаяа нарт тус бүр 4000 төгрөг, бүгд 8000 төгрөгийн ажлын хөлс олгож, захиргааны зардалд тооцон зарлагадахыг компанийн гүйцэтгэх захирал М.Оюун зөвшөөрсүгэй.

ТУЗ-ЫН ДАРГА **ДАРХАН ТЭЭВЭР ХК** Ж.ОЧИРСҮХ



Дархан Уул аймгийн Дархан тээвэр ХК-ний  
Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл

Компанийн нэр: ...Дархан Тээвэр ХК...

Хаяг, утас: Дархан Уул аймаг, Дархан сум, 7-р баг, Монгол Алт ХК-ний байр,  
0137234126, 99081364

Хурал хуралдах огноо,цаг,газар

2010 оны 04 сарын 26-ны 13 цаг

... Монгол Алт ХК-ны хурлын зааланд ...

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо

... 2010 оны 03 сарын 21-ны өдөр ...

Олон нийтэд зарлах огноо

... 2010 оны 03 сарын 25-ны өдөр .....

Бүртгэх өдөр

... 2010 оны 03 сарын 30-ний өдөр ...

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх  
огноо.....

Хүргүүлсэн огноо ... 2009 оны 03 сарын 24-ны өдөр ...

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ..... ширхэг, .....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН ДАРГА...../ Ж.Очирсүх /

..... оны ..... дүгээр сарын .....-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН:

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН...../ /

..... оны ..... дүгээр сарын .....-ний өдөр

## Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдлийн хавсралт

1. **Хурал зарлагч этгээдийн хурал хуралдуулах шийдвэр**  
ТУЗ-ийн 2010 оны 03 сарын 21-ны өдрийн “Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” тогтоол
  - **Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар**
  - Компанийн 2009 оны санхүүгийн тайлан
  - ТУЗ-ийн тайлан
  - ХШЗ-ийн тайлан
  - Ногдол ашиг тараах тухай батлах
2. **Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, цаг;**  
Компанийн 2009 оны санхүүгийн тайлан  
ТУЗ-ийн 2009 оны ажлын тайлан  
ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан  
зэрэг хурлын материалтай хуралд оролцох эрх бүхий хувь нийлүүлэгчид нь 2010 оны 03 сарын 30-ний өдрөөс 2010 оны 04 сарын 23-ны ажлын өдрүүдэд компаний байранд ирж танилцаж болно.
3. **Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;**  
Комиссын дарга Ж.Очирсүх ----- утас:99083719, 362542, e-mail: [DAR\\_broker@yahoo.com](mailto:DAR_broker@yahoo.com)  
гишүүн Ж.Мягмаа ----- утас:99081267
4. **Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь Компанийн тухай хуулийн 67.1, 67.2-т заасны дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар**  
Санал оруулаагүй болно.
5. **Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа:** 2010 оны 03 сарын 30 нд

**ДАРХАН -УУЛ АЙМГИЙН “ДАРХАН ТЭЭВЭР”**

**ХУВЬЦААТ КОМПАНИ**

Дархан сумын 7-р баг “Монгол-Алт” ХК-ний байр.

Утас : 34126 Fax: 0137234126, ш/х № 900

2010 оны 03 сарын 25-ны өдөр

Дугаар <sup>#108</sup> . . . . .

Дархан хот

**“Үнэт цаасны төлбөр тооцоо  
төвлөрсөн хадгаламжийн төв”ХХК-д**

Манай компани нь хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаа зарласан тул хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг 2010 оны 03 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон ирүүлнэ үү.

ТУЗ-ийн дарга...../Ж.Очирсүх/





# ӨДРИЙН СОНИН

2000, 2002, 2003, 2005 оны шилдэг сонин  
2002 оны "Хүний эрхийг хөхиүлэн  
дэмжигч сонин"

2010.03.25 ПҮРЭВ №071 (3461) Үнэ 500 төг

## ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН АНХААРАЛД

1. Дархан-Уул аймаг дахь "Дархан Тээвэр" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 26-ны өдрийн 13.00 цагт "Монгол алт" ХК-ийн хурлын танхимд хуралдана.
2. Бүртгэх өдөр: 2010 оны гуравдугаар сарын 30
3. Хурлаар хэлэлцэх асуудлууд:
  - ТУЗ-ийн 2009 оны тайлан
  - ХШЗ-ийн 2009 оны тайлан
  - Санхүүгийн үйл ажиллагааны тайлан,
  - Ноогдол ашиг тараах тухай

Утас: 99083719, Факс: 0137234126

## ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН АНХААРАЛД

1. Дархан-Уул аймаг дахь "Монгол Алт" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 26-ны өдрийн 09.00 цагт компанийн хурлын танхимд хуралдана.
2. Бүртгэх өдөр: 2010 оны гуравдугаар сарын 30
3. Хурлаар хэлэлцэх асуудлууд:
  - ТУЗ-ийн 2009 оны тайлан
  - ХШЗ-ийн 2009 оны тайлан
  - Санхүүгийн үйл ажиллагааны тайлан,
  - Ноогдол ашиг тараах тухай

Утас: 99371230, Факс: 0137233263

## ЭРДМИЙН ЗЭРЭГ ХАМГААЛНА

Удирдлагын академийн докторант Батболд овогтой Баясгалан нь "Төсвийн шинэчлэл: хэрэгжилт, хандлага" сэдвээр докторын зэрэг хамгаална.

Хамгаалалт 2010 оны дөрөвдүгээр сарын 22-ны өдрийн 14.00 цагт Удирдлагын академийн 208 тоот танхимд болно.

Хамгаалуулах зөвлөл

## ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН АНХААРАЛД

1. Дархан-Уул аймаг дахь "Содот" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 26-ны өдрийн 16.00 цагт "Монгол алт" ХК-ийн хурлын танхимд хуралдана.
2. Бүртгэх өдөр: 2010 оны гуравдугаар сарын 30
3. Хурлаар хэлэлцэх асуудлууд:
  - Компанийн дүрмийг шинэчлэн батлах
  - Санхүүгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, Шинээр ТУЗ болон ХШЗ-ийн гишүүдийг сонгох сонгууль явуулах.
  - Компанийн ТУЗ, ХШЗ-д нэрээ дэвшүүлэх хүмүүсийн бичгээр гаргах хүсэлтийг хурал зохион байгуулах комисст 2010 оны дөрөвдүгээр сарын 23-ны өдрийг дуустал хүлээн авна.

Утас: 99371230, Факс: 0137233263

## ГЁТЕ дунд сургууль

БЭЛТГЭЛ АНГИД  
ЭЛСЭЛТ АВЧ БАЙНА

БҮРТГЭЛ:

2010.03.20-ноос


4-9-р ангийн сурагчдаас математик, хими, физик, газарзүйн хичээлээр шалгалт авч тодорхой болзол хангасан сурагчдыг ярилцлагад оруулж, шалгарсан сурагчдыг төлбөргүй сургана.

IV сарын 7 хүртэл бүртгэнэ.  
IV сарын 10нд шалгалт авна.



## ОЛОН УЛСЫН 8 ДАХЬ БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

8th International Education Exhibition 2010 Mongolia



2010.03.27-28

"Чингис Хаан" Зохио Бүтээл

Голданийн сургуулийн дээд сурмараа болон  
диплом суралцах боломжтой

100% IELTS, TOEFL, ASK, IELTS ба хамтатгуулдаг  
Англи, Франц, Япон, Испани, Итали, Германи, Орос, Хятад

Хувиараа эрхэн, үтгэлтэй хариуцах болон  
Зөвхөн үнэмлэхүйгээр хариуцах боломжтой

Бүртгэл/семинар 11.00-18.00 цаг хүртэл

ОЛОН УЛСЫН НЭР ХҮНДТЭЙ СУРГУУДУУДАД ЭЛСЭН  
СУРАЛЦАХ БОЛОМЖНИЙГ БИД ТА БҮХЭВД ОЛГОЖ БАЙНА.

NSW Department of Education and Training Australia  
Swiss Universities

Johnson & Wales University

Fairleigh Dickinson University

SAIT Polytechnic

United Institute of Technology

Hibernia Institute Brisbane

Swiss Hotel Management School

Sidney College of Business and IT

Oxford Language Centre





УШТТХТ

**“ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР  
ТООЦОО ТӨВЛӨРСӨН  
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК**

211213 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
УБД-22/373, Сүхбаатарын талбай 2, Утас: 7011-34-97,  
Факс: 7011-44-24

2010.04.08. № 2/346  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ТЭЭВЭР ДАРХАН” ХК-д

*Судалгаа хүргүүлэх тухай*

Танайхаас ирүүлсэн 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/В тоот албан бичгийн дагуу “Тээвэр Дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг 2010 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон гаргаж тус тус хавсралтаар хүргүүлэв.

Хавсралтанд:

1. Үнэт цаас эзэмшигчдийн судалгаа / 2 хуудас/
2. Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаа /1 хуудас/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ГАНДУЛАМ

0000346



## ҮЦ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРААНГУЙ СУДАЛГАА

Үнэт цаас: 217-ТЭЭВЭР ДАРХАН  
Бүртгэх өдөр : 2010-03-29  
Судалгаа гаргасан огноо : 4/8/2010

Зарласан ширхэг: 163,349  
Гаргасан ширхэг: 163,349  
Арилжаалагдаагүй ширхэг: 0  
Зөрүү: 0

№	БДК код	БДК -ийн нэр	Үндсэн захиргаа	Тоо ширхэг	Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
1	1	Ноён суудал		175	1
2	2	Масдак		8	2
3	5	Зэргэд		560	2
4	6	Мэргэн санаа		362	3
5	7	Би ди сек		840	3
6	8	Орчил инвест		2	1
7	9	Өндөрхаан инвест		200	1
8	12	Хөвсгөл бирж		286	3
9	13	Булган брокер		1,000	8
10	14	Ажнай инвест		300	2
11	15	Дархан брокер		157,345	10
12	17	Эрдэнэст		7	1
13	20	Мөнхөд		200	1
14	21	Бумбат-Алтай		981	6
15	26	Шанд эрдэнэ		101	2
16	27	Аргай бест		140	1
17	29	Дэлгэрхангай секюритиз		228	5
18	31	Гендекс		107	1
19	33	Гансек		118	2
20	42	Ханш инвест		286	1
21	50	Ди си эф		3	1
22	53	Санхүүгийн хөгжил инвест		100	1
			<b>Нийт :</b>	<b>163,349</b>	<b>58</b>

Тусгаарлагдсан үнэт цаас: 1

<b>Компанийн нэр</b> ДАРХАН ТЭЭВЭР	<b>Админы нэр</b> ТЭЕ	<b>Нууц үг</b> 10217000
---------------------------------------	--------------------------	----------------------------

Судалгаа гаргасан : ..... Б.Батсүрэн

Судалгааг хянасан : ..... Ч.Андсайхан

**ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДИЙН СУДАЛГАА**

Үнэт цаасны нэр : ТЭЭВЭР ДАРХАН Нийт зарласан хувьцааны тоо : 163,349  
 Нийт гаргасан хувьцааны тоо : 163,349 Бүртгэх өдөр : 2010-03-29

**БДК : (1) Ноён суудал**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
1	9 ГАЛСАН	ЧУЛУУН	ЙЮ34081719	175	*	
Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1				175		

**БДК : (2) Масдак**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
2	Д	ЛХАГВАЖАВ	МТ51091411	4	*	
3	КОМПАНИ ХҮСЭЛТ	ДОЛЖИНЖАВ	СБ02000104	4	*	
Данс нээгдсэн : 2 Нээгдээгүй : 0 нийт : 2				8		

**БДК : (5) Зэргэд**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
4	Н	ОДОНТУЯА	ПЮ54051506	420	*	
5	0	АЛТАНГЭРЭЛ	СЮ51011773	140	*	
Данс нээгдсэн : 2 Нээгдээгүй : 0 нийт : 2				560		

**БДК : (6) Мэргэн санаа**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
6	Д	ЦЭЦЭГМАА	ХД71061061	87	*	
7	КОМПАНИЙН ХҮСЭЛТ	БАДАМ	ЦБ25030801	100	*	
8	КОМПАНИЙН ХҮСЭЛТ	АНХУЯГ	АЕ21111568	175	*	
Данс нээгдсэн : 3 Нээгдээгүй : 0 нийт : 3				362		

**БДК : (7) Би ди сек**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
9	Ш	АЛТАНГЭРЭЛ	ХЮ72010974	525	*	
10	КОМПАНИЙН ХҮСЭЛТ	ДАШДОНДОГ	НЭ29071079	175	*	
11	КОМПАНИЙН ХҮСЭЛТ	УНДРАХТУЯА	СУ65091569	140	*	
Данс нээгдсэн : 3 Нээгдээгүй : 0 нийт : 3				840		

**БДК : (8) Орчил инвест**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
12	Ж	БАТТУЛГА	ДР57022405	2	*	
Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1				2		

**БДК : (9) Өндөрхаан инвест**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
13	КОМПАНИЙН ХҮСЭЛТ	ДЭНДЭВ	ХК09111703	200	*	
Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1				200		

**БДК : (12) Хөвсгөл бирж**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
14	ЦЭНД-АЮУШ	ХЭНМЭДЭХ	ФЖ68020216	175	*	
15	ГОМБООЧИР	ПҮРЭВЖАВ	РЭ53071069	93	*	
16	Х	БАЯРСАЙХАН	РЭ66122512	18	*	
Данс нээгдсэн : 3 Нээгдээгүй : 0 нийт : 3				286		

Судалгаа гаргасан : ..... Б.Батсүрэн

Судалгааг хянасан : ..... Ч.Андсайхан

## БДК : (13) Булган брокер

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
17	И	БЯМБАДОРЖ	ГО56031079	300	*	
18	Л	ЭРДЭНЭБАЯР	ГО59021175	100	*	
19	Д	БАТМӨНХ	ГО64080372	100	*	
20		КОМПАНИЙН ХҮСЭГЭРДЭНЭЧИМЭГ	ГО60082761	100	*	
21	Н	АЛТАНЦЭЦЭГ	ГО60051464	100	*	
22		КОМПАНИЙН ХҮСЭГБУЛГАНЖАВ	ГО85090984	100	*	
23		КОМПАНИЙН ХҮСЭГБААТАРХҮҮ	ГО87102471	100	*	
24		КОМПАНИЙН ХҮСЭГТУНГАЛАГ	ГО76101864	100	*	
Данс нээгдсэн : 8 Нээгдээгүй : 0 нийт : 8				1,000		

## БДК : (14) Ажнай инвест

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
25		КОМПАНИЙН ХҮСЭГСУМЪЯА	К354030807	100	*	
26		ЖҮГДЭР БАТЧУЛУУН	КЮ48060412	200	*	
Данс нээгдсэн : 2 Нээгдээгүй : 0 нийт : 2				300		

## БДК : (15) Дархан брокер

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
27	НАМСРАЙ	МӨНХЗУЛ	ТЖ61101701	6,916	*	
28	4 ГОМБОСҮРЭН	ЧИМГЭЭ	ТД56012609	140	*	
29	ЛУВСАНДАМБА	АМАРСАНАА	Т353051776	7,712	*	
30	ЖАМБАЛ	ОЧИРСҮХ	ТЕ63082579	60	*	
31	ЖАМБАЛ	МӨНХТӨР	ТЕ57060916	31,603	*	
32	Д	ГАНБАТ	ТА59092071	341	*	
33	<хвсэлтээр>	ДАНСРАН	ТИ62082576	140	*	
34	2 М	ОЮУН	ТИ57070121	24,518	*	
35	МӨНХТӨР	"МОНГОЛ АЛТ" ХК	ТИ57060916	83,308	*	
36	ОЧИРСҮХ	ЗОЛБОО	ТИ88110517	2,607	*	
Данс нээгдсэн : 10 Нээгдээгүй : 0 нийт : 10				157,345		

## БДК : (17) Эрдэнэст

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
37	0	НАРАНЦЭЦЭГ	ФБ59063001	7	*	
Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1				7		

## БДК : (20) Мөнхөд

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
38	Л	ГАНТУЯА	ТА59072066	200	*	
Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1				200		

## БДК : (21) Бумбат-Алтай

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
39	Х	ДОРЛИГ	ПЮ50031516	248	*	
40	Х	БАТТУЛГА	М365012614	140	*	
41	Б	БААТАРЖАВ	ПЮ66020371	128	*	
42		КОМПАНИЙН ХҮСЭГОЧИРБАТ	ХК09111704	155	*	
43	Ч	ЭНХБОЛД	ПЮ74041076	155	*	
44	Ч	ЭНХТҮВШИН	ПЮ75122772	155	*	
Данс нээгдсэн : 6 Нээгдээгүй : 0 нийт : 6				981		

## БДК : (26) Шанд эрдэнэ

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
45	ЮМДОРЖ	ИДЭРЦОГТ	ЧН73030412	100	*	
46	БААСАН	ЦЭРЭН	ШБ73092571	1	*	1
Данс нээгдсэн : 2 Нээгдээгүй : 0 нийт : 2				101		1

## БДК : (27) Аргай бест

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
--------	------	-----	---------	------------	---------------	---------------

Судалгаа гаргасан: ..... Б.Батсүрэн

Судалгааг хянасан: ..... Ч.Андсайхан

Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1 140

**БДК : (29) Дэлгэрхангай секюритиз**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
48	<хвсэлтээр>	ТӨМӨРБААТАР		97	*	
49	КОМПАНИЙН ХҮСЭЛПҮРЭВДУЛАМ		УГ71050668	1	*	
50	Д	САМБУУ	ХВ48031894	2	*	
51	Н	ОЮУНБИЛЭГ	УГ58042927	127	*	
52	КОМПАНИЙН ХҮСЭГЭДЪЯАХҮҮ		ҮД43070167	1	*	

Данс нээгдсэн : 5 Нээгдээгүй : 0 нийт : 5 228

**БДК : (31) Гендекс**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
53	Г	БААТАР	ДЮ63100510	107	*	

Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1 107

**БДК : (33) Гансек**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
54	БЭЛТРЭГ	ОЮУНЦАЦРАЛ	МЛ63031604	2	*	
55	БЭГЗ	СУУРЬСҮРЭН	ИЭ47062217	116	*	

Данс нээгдсэн : 2 Нээгдээгүй : 0 нийт : 2 118

**БДК : (42) Ханш инвест**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
56	Л	МЯГМАРСҮРЭН	ГО49062161	286	*	

Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1 286

**БДК : (50) Ди си эф**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
57	Т	ГАНХУЯГ.Т	ХН61020679	3	*	

Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1 3


**БДК : (53) Санхүүгийн хөгжил инвест**

Дугаар	Овог	Нэр	Регистр	Тоо ширхэг	Нээгдсэн эсэх	Тусгаарл -сан
58	Д	БАЯРСАЙХАН	ЧК65112474	100	*	

Данс нээгдсэн : 1 Нээгдээгүй : 0 нийт : 1 100

Нийт ( 58 ) 163,349.00 1

Судалгаа гаргасан : ..... Б.Батсүрэн

Судалгааг хянасан :  Ч.Андсайхан

“Дархан Тээвэр” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн  
хуралд оролцогчдод мандат олгосон бүртгэл

2010 он 04-р сар 26-ны өдөр

Дархан сум

д/д	Овог нэр	Мандатын дугаар	Саналын эрх			Мандат хүлээн авагчийн гарын үсэг
			Эзэмшсэн	Төлөөлсөн	Бүгд	
1.	М. Монхгар	1.	31603	83 308	114911	<i>[Signature]</i>
2.	М. Оюун	2.	24518		24518	<i>[Signature]</i>
3.	М. Оюунсүх	3.	60	9523	9583	<i>[Signature]</i>

Нийт хувьцаа: 163349  
Ирсэн нь: 149012.  
Ирцын хувь: 91,2%

Тооллогын комиссын дарга: *[Signature]*  
*[Signature]*

ИТГЭМЖЛЭЛ

2010.04.22

/он, сар, өдөр/

115 хөтө

/үйлдсэн газар/

Иргэний хуулийн 62.3 дахь хэсгийн заалтыг үндэслэн

БГД Н- хороо 2- хорооноос Монгол улсад 5-14 -д оршин суух Минсэрал -ийн Монхуу би энэхүү итгэмжлэлийн дагуу Булган-тотбог, ХХ УОГ Хувь Нийгмийн Засаг захирал газрын хувьцааны эзэмшүүлэх гэрээ, үүрхийг гүйцэтгэх

үйлдэл хийх эрхийг БГД Н- дундгал 5-2-14 -д оршин суух Минсэрал -ийн Оширцуу -нд итгэмжлэн олгож байна.

Энэхүү итгэмжлэл нь олгосон өдрөөс эхлэн 1(нэг) /сар, 2 жил/-ын хугацаанд хүчинтэй болно.

ИТГЭМЖЛЭГЧ :

Н. Монхуу /нэр/ М. Оширцуу /гарын үсэг/  
Иргэний үнэмлэхийн № УБ0808711  
Регистрийн № ТЖ 61101701

ИТГЭМЖЛЭГДЭГЧ :

М. Оширцуу /нэр/ Н. Оширцуу /гарын үсэг/  
Иргэний үнэмлэхийн № УБ1043250  
Регистрийн № ТЭБ3082579

Тамга

Нотариатч \_\_\_\_\_

2010 04 22

117

Н. Оширцуу  
2010  
Н. Оширцуу

## ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг танилцуулах
2. Хурлыг нээх
3. Тооллогын комиссыг ажилд оруулах
4. Хурлын даргыг сонгох
5. Хурлын дэг батлуулах
6. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журам батлуулах
7. ТУЗ, ХШЗ, Санхүүгийн тайлан хэлэлцүүлэх
8. Тайлангуудтай холбоотой асуулт хариулт явуулах
9. Санал шүүмжлэл
10. Санал хураалт явуулах
11. Санал хураалтын дүн танилцуулах
12. Хурлаас гарах тогтоолын төслийг батлуулах

Үүнд: ТУЗ-ийн тайланг хэлэлцсэн тухай  
ХШЗ-ийн тайлан хэлэлцсэн тухай  
Ногдол ашиг хуваарилах тухай  
2009 оны санхүүгийн тайлангийн тухай  
Компаний нэрийг өөрчлөн "Алтан Сагс"ХК болгох тухай

13. Хурлыг хаах

### ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. ТУЗ-ийн тайлан
2. ХШЗ-ийн тайлан
3. Санхүүгийн тайлан
4. Ногдол ашиг хуваарилах тухай
- 5.

### ХУРЛЫН ДОТООД ЖУРАМ

- |   |                                     |                |
|---|-------------------------------------|----------------|
| 1. ТУЗ-ийн тайлан                           | Илтгэгч ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх     | 10 мин         |
| 2. ХШЗ-ийн тайлан                           | Илтгэгч ХШЗ-ийн дарга С.Дэмид-очир  | 10 мин         |
| 3. Санхүүгийн тайлан                        | Илтгэгч ерөнхий ня-бо Д.Бямбажаргал | 15 мин         |
| 4. Санал шүүмжлэл хүн тус бүр               |                                     | 5 мин          |
| 5. Хурлаас гарах шийдвэрийг хэлэлцэн батлах |                                     | цаг тогтоохгүй |

Хурлыг 2010 оны 04-р сарын 26-ний 13.00 цагт эхэлж 15.30 дуусгана.

**Дархан Тээвэр” ХК-ний 2009 оны  
бүх гишүүдийн хурлын тэмдэглэл**

2010.04.26

Дархан Уул аймаг

Хуралдсан газар: Дархан Уул аймаг, Дархан сум, 7-р баг, “Монгол Алт” ХК-ийн хурлын танхим

Хуралдсан хугацаа: 2010 оны 04 сарын 26-ны 14 цаг

Хуралд оролцогчид:- Хувьцаа эзэмшигчид

- ТУЗ-ын дарга Ж.Очирсүх
- ТУЗ-ын гишүүн Ж.Мөнхтөр
- ХШЗ-ийн дарга Б.Дэмид-Очир
- ТУЗ-ын гишүүн Ж.Мягмаа
- Захирал М.Оюун
- Ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал
- Тооллогын комиссыг дарга Ж.Мягмаа
- Тооллогын комиссын гишүүн Э.Золзаяа нар оролцов.

Хурлын ирцийг ТУЗ-өөс томилсон тооллогын комиссын дарга танилцуулав.

Хуралд нийт 163349 хувьцааны 149012 ширхэг хувьцааг эзэмшигч 3 гишүүн оролцож, хурлын ирц 91.2%-тай байгаа тул хурлыг эхлүүлэв.

Хуралд оролцогч гишүүдээс хурлын даргаар Ж.Мөнхтөрийг сонгов.

Хурлын дарга хурлын дэг, дотоод журмыг хэлэлцүүлж батлав.

**Ж.Мөнхтөр:** Хурлаар: 1. ТУЗ-ийн тайлан

2. ХШЗ-ийн тайлан

3. Компаний 2009 оны санхүүгийн тайлан

4. Ноогдол ашиг тараах тухай

5. Компаний нэр солих тухай асуудлуудыг хэлэлцэхээр

хувь нийлүүлэгчид санал нэгтэй батлав.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу ТУЗ-ийн 2009 оны хийсэн ажлын тайланг ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх, компаний ХШЗ-өөс 2009 онд хийсэн ажлын тайланг ХШЗ-ийн дарга Б.Дэмид-Очир, компаний 2009 оны санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал нар тус тус танилцуулав.

**Ж.Мөнхтөр:** Хурлын дэгийн дагуу ТУЗ, ХШЗ, санхүүгийн тайлангуудын талаар тодруулах асуулт, санал хүсэлт байна уу гэв.

**Б.Дэмид-очир:** Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бэрхшээл хүндрэлтэй юм байна уу? ХХК байхаас ХК-д шилжихэд хүндрэл байна уу?

**Ж.Мөнхтөр:** Миний хувьд байгааг бодож байна. Хөрөнгө бага, элэгдлийн хөрөнгийн шимтгэл өндөр учир ашиг их гардаг. Орлогоо нэмэгдүүлэхгүй байгаа. Түрээсээ нэмэхгүй харин ч хөнгөлдөг. Компания бод. Худалдааны заалны талбайн ашиглалтыг бодохгүй судлахгүй байна. Хийсэн юм байвал хурал дээр үзүүл, байхгүй бол “Монгол Алт”ХК нь дээр авч ирж үзүүл.

**Ж.Очирсүх:** Тэр тал дээр ТУЗ-ийн гишүүд хуралдаж хэлэлцсэн.

**Ж.Мөнхтөр:** Цахилгаан эрчим хүч, дулааны үнэ нэмэгдсэн байхад яагаад түрээсийн үнэ нэмэгдэхгүй байна вэ? Тэр нь дээрээс алдагдал хүлээж байна. Нэг талтай бодлого явуулж байна. Түрээслэгчээ алдахгүй байх нь зөв. 5000-6000 төгрөг болно.

**М.Оюун:** 2008 оны эцсээр нэмсэн. Өвлийн улиралд тустай тоолууртай цайны газар болон зааланд дулаан хангалт гэж түрээс нь дээр нь мөнгө нэмэж авдаг.

**Ж.Мөнхтөр:** 2009 онд Цахилгааны үнэ хэдэн төгрөг төлсөн?

**Д.Бямбажаргал:** 44 сая төгрөг төлсөн байна.

**М.Оюун:** Үнэ нэмэхгүй байгаа гол шалтгаан нь их хүндрэлтэй асуудлууд гардаг. Чингэлэгийн хүмүүс өргөдөл гаргасан. Үнэ бууруулах шаардлага тавьсан. Үнэ дээр судалгаа хийж цаашид нэмэгдэнэ гэж хэлсэн. 2009 он гарсаар ОУХ төв дээр урсгал төвлөрч хуваагдсан. Энэ дээр болгоомжтой хандаж байгаа. Үнэ нэмэх боломж юу байна гэдгийн Бямбажаргалтай ярилцаж байгаа. Гарцаагүй шалтгаан байгаа учраас үнэ нэмэхгүй байгаа.

**Ж.Мөнхтөр:** “Алтан Сагс” ХК болгох ажлыг Очирсүхд даалгая. Тодорхой үр дүнд хүргэж ажиллаарай.

Үнэлгээний талаар ярилцъя. Үнэ зардалаа тохиролц, үнэлүүл, ашиг орлогоо тооцоол, элэгдэлээ тооцоол, засварын зардлаа тооц. Бүх талаас нь бодолцож үнэлүүлээрэй.

**М.Оюун:** “Дархан Зах”-ыг 2010 онд ашиглалтанд оруулъя гэсэн санал байна. Төлөвлөгдөөгүй зардлууд байгаа. Лангуу, гал унтраагуур зэргийг тооцоолоогүй байна. 200 сая төгрөг шаардлагатай байна. Гал унтраагуур л гэхэд 25 сая төгрөг болж байгаа. Доор байгаа кафены үйл ажиллагааг эхлүүлэх үүрэг өгсөн. Төсөв мөнгө хэрэгтэй байгаа. Тийм учраас зээл авах хэрэгтэй байна. Энэ дээр банкны хүзүгийн асуудал хүндрэлтэй байна. Манай компани огт зээл авч байгаагүй учраас хүү 2%-иас дээш гараад байна.

**Ж.Мөнхтөр:** Үнэлгээгээ хурдан гаргуулаарай. Хурлын дэгийн дагуу ноогдол ашиг олгох тухай хэлэлцье.

**М.Оюун:** 2010 онд нийт төлөвлөсөн орлого 79 сая төгрөг байгаа.

**Ж.Мөнхтөр:** 11 хувийн өгөөжтэй байна. Иймд ноогдол ашгийг 300 төгрөгөөр тогтооё. Өөр санал хүсэлт байна уу?

Гишүүдээс ямар нэг санал, хүсэлт гарсангүй.

**Ж.Мөнхтөр:** Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын тайлан, ХШЗ-ийн тайлан, Санхүүгийн тайланг хэлэцсэн тул тайлангуудад үнэлэлт өгөхөөр санал хуралт явуулъя,

Тооллогын комиссоос саналын хуудсыг тарааж санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Ж.Мягмаа санал хураалтын дүнг танилцууллаа.

Хурлын дарга тооллогын комиссын тогтоолыг үндсэлэн бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэр болох

1. ТУЗ-ийн ажилд бүх гишүүдийн 100 %-ийн саналаар “Сайн” гэсэн үнэлэт өгсөн тухай
2. ХШЗ-ийн ажилд бүх гишүүдийн 100 %-ийн саналаар “Сайн” гэсэн үнэлэт өгсөн тухай
3. Ноогдол ашгийг нэгж хувьцаанд 300 төгрөгөөр тооцож олгох тухай
4. ТУЗ-ийн зөвлөлөөс компаний нэрийг “Алтан Сагс”ХК болгох тухай гэсэн тогтоолуудын төслийг танилцуулж батлууллаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга..........Э.Золзаяа

**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ  
“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ  
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2010 оны 04 сарын 26 өдөр

№01

Дархан сум

Компанийн ТУЗ ба ХШЗ-ийн 2009  
оны ажлын тайланг авч хэлэлцсэн дүнгийн тухай

“Дархан Тээвэр”ХК-ийн 2010 оны 04 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2009 оны ажлын тайланг авч хэлэлцээд хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн 2009 онд хийсэн ажлын тайланг сонсч хэлэлцээд хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2009 оны ажлыг “Сайн” гэж дүгнэсүгэй.
2. ХШЗ-ийн 2009 онд хийсэн ажлын тайланг сонсч хэлэлцээд хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар ХШЗ-ийн 2009 оны ажлыг “Сайн” гэж дүгнэсүгэй.

Хурлын дарга



Ж.Мөнхтөр

**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ**  
**“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ**  
**НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2010 оны 04 сарын 26 өдөр

№ 02.

Дархан сум

Ногдол ашгийн хэмжээг тогтоох тухай

“Дархан Тээвэр” ХК-ийн 2010 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар тус компанийн санхүүгийн тайлан, ногдол ашиг тараах асуудлаар тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. 2009 оны үйл ажиллагааны үр дүнгээр “Дархан Тээвэр ” ХК-ийн ээлжит хуралд оролцогсдын 100 хувийн саналаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 300 төгрөгөөр тогтоосугай.
2. Ногдол ашгийг 2010 оны 09 сарын 01-ний дотор олгохыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурлын дарга



Ж.Мөнхтөр

**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ**  
**“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ**  
**НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2010 оны 04 сарын 26 өдөр

№ 03

Дархан сум

Компаний нэрийг өөрчлөх тухай

“Дархан Тээвэр” ХК-ийн 2010 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар компаний нэр өөрчлөх тухай хэлэлцсэн хурлаар **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн гишүүд хэлэлцээд хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар компанийн нэрийг “Алтан Сагс”ХК болгохыг дэмжив.
2. “Алтан Сагс”ХК болгон өөрчлөх ажлыг ТУЗ-ын дарга Ж.Очирсүхд даалгасугай.

Хурлын дарга



Ж.Мөнхтөр

**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ  
“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

---

2010 оны 04 сарын 26 өдөр

№04

Дархан сум

Ногдол ашиг олгох санал  
хураалтын дүнгийн тухай

“Дархан Тээвэр ” ХК-ийн 2010 оны 04-р сарын 26-ны өдрийн хурлын тооллогын комисс ногдол ашиг олгох санал хураалтын дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**


1. Саналын хуудас 3 ш-г тарааж , хайрцаг задлахад 3 ш саналын хуудас гарав.
2. Саналын хуудас бүгд хүчинтэй байв.
3. Санал хураалтаар :


100 төгрөг - санал буюу 0 %

200 төгрөг - санал буюу 0 %

300 төгрөг 149012 санал буюу 100 % -ийн санал авсан

дүн гарсан тул 2009 оны ногдол ашгийг олонхийн буюу 100 %-ийн саналаар 300 төгрөгөөр олгохоор санал оруулсугай.

Тооллогын комиссын дарга  Ж.Мягмаа  
Э.Золзаяа



**ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ  
“ДАРХАН ТЭЭВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2010 оны 04 сарын 26 өдөр

№ 05

Дархан сум

ТУЗ, ХШЗ-ийн тайланд үнэлэлт  
өгөх тухай

“Дархан Тээвэр ” ХК-ийн 2010 оны 04-р сарын 26-ны өдрийн хурлын тооллогын комисс ТУЗ, ХШЗ-ийн ажилд дүгнэлт өгөхөөр явуулсан санал хураалтын дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. Саналын хуудас 3 ш-г тарааж , хайрцаг задлахад 3 ш саналын хуудас гарав.
2. Саналын хуудас бүгд хүчинтэй байв.
3. Санал хураалтаар

**ТУЗөвлөл**

Онц	-	санал буюу	0.0 %
Сайн	149012	санал буюу	100 %
Дунд	-	санал буюу	0 %

**ХШЗөвлөл**


Онц	-	санал буюу	0%
Сайн	149012	санал буюу	100 %
Дунд	-	санал буюу	0 %

**Санхүүгийн тайлан**

Онц	-	санал буюу	0%
Сайн	149012	санал буюу	100 %
Дунд	-	санал буюу	0 %

-ийн санал авсан дүн гарсан тул ТУЗ-ийн ажлыг олонхийн саналаар “Сайн” дүнтэй, ХШЗ-ийн ажлыг олонхийн саналаар “Сайн” дүнтэй батлуулах санал оруулсугай.

Тооллогын комиссын дарга



Ж.Мягмаа  
Э.Золзаяа

Бүх гишүүдийн 2010 оны 04 сарын 26-ны  
өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

**“Дархан тээвэр” ХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2009 онд хийсэн ажлын тайлан.**

2010.04.26

Дархан сум

**Эрхэм хувьцаа эзэмшигчдээ.**

“Дархан Тээвэр” ХК нь 163349 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 2010 оны 4-р сарын 08 ны байдлаар 58 хувьцаа эзэмшигчтэй байна. Нийт энгийн хувьцааны 96% буюу 158000 ширхэг хувьцааг эзэмшигч нь тус компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад ажиллаж байна.

“Дархан Тээвэр” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөл тус компанийн 2009 оны бизнес төлөвлөгөөг баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай болон бусад хууль тогтоомж шийдвэр, “Дархан Тээвэр” хувьцаат компанийн дүрмийг мөрдөж, компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь төлөөлөн удирдах зөвлөлийн удирдлага, шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан “Дархан тээвэр” ХК-ний Бизнес төлөвлөгөөний гол зорилт нь “ 2009 онд компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох үйлчилгээний газруудын үйл ажиллагааг өнөөгийн хүрсэн түвшингээс 20-иос илүү хувиар бууруулахгүй байх бодлого баримтлах, орлого нэмэгдүүлэх , тэвчиж болох зардлыг танах замаар өнгөрсөн оны ашгийн түвшинг бууруулахгүй ажиллах” гэсэн нь санхүү эдийн засгийн хямралтай үед бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангах байсан билээ.

Энэ хүрээнд 2009 онд 825.8 сая төгрөгийн орлого олж, 735.3 сая төгрөгийн зардал гарган, 77.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн.

**Нэг: Дотоод ажлын талаар**

Тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас оруулсан саналуудыг хэлэлцэхээр 1 удаа хурал хийж

-Хуримтлагдсан ашгаас хасалт хийх тухай саналыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Компанийн болон Үнэт цаасны тухай хуулиудын дагуу “Дархан Тээвэр” ХК-ний хурлын материал санхүүгийн тайлан, балансыг хөрөнгийн биржид хүргүүлж, хувьцааг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй гэрээ

байгуулан хадгалуулж гишүүний болон хадгаламжийн төлбөр хураамжийг төлж байна.

### **Хоёр:Компанийн үйл ажилгааны талаар**

2009 оны бизнес төлөвлөгөөнд компанийн орлогыг 825.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 961.4 сая төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөө 16.4% иар буюу 135.6 сая төгрөгөөр давж биелэсэн хэдий ч өнгөрсөн оны гүйцэтгэлээс 22.4 % иар буурсан дүнтэй байна.Энэ бууралт санхүү эдийн засгийн хямрал, иргэдийн худалдан авах чадвар, түрээслэгчдийн орлого буурсантай холбогдуулж түрээсийн төлбөрийг 4-7 сарыг дуустал 15-20%иар бууруулсантай холбоотой гэж үзэж байна. Компанийн бизнес төлөвлөгөөнд зардлыг 735.3 сая төгрөг байхаар төлөвлөсөнөөс 671.2 сая төгрөгийн зардал гаргасан нь зардлыг 8.7% иар хэмнэжээ.

Компани 2009 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр 961.4 сая төгрөгний орлоготой, 671.2 сая төгрөгний зардалтай, 253.9 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

- 2008 онд 398.0 сая төгрөгний барилгын ажил хийгдсэн 9400 метр кв талбайтай 500 ажлын байр бүхий “Дарханы зах” худалдаа үйлчилгээний төвийн засварын ажлыг эдийн засгийн хямралт байдал, хөрөнгө санхүүгийн хомсдолоос шалтгаалан 2009 онд бүрэн зогсоосон бөгөөд Шинэ зах, Шинэ орчин төв, Буян захын үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад сэлбэг, хангамж барилгын материал, урсгал засварт 167.6 сая төгрөг зөрцуулсан байна.
- Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах зарилгоор өөрийн ариун цэврийн лабораторийн хэрэгцээнд сүүний 8 төрлийн чанарын үзүүлэлт тодорхойлох лактоскайн багаж худалдан авч малын гаралтай бүтээгдэхүүний шинжилгээг хурдан шуурхай илрүүлэх тестийн аргыг нэвтрүүлсэн.
- Байгаль орчны бохирдлыг багасгах зорилгоор хог хаягдлыг НААҮГ-тай гэрээ байгуулан зайлуулж жилдээ 6.1 сая төгрөг зарцуулж, Шинэ захын цайны газруудын бохир зайлуулах 110 метр шугам хоолойг шинээр солиход 8.1 сая төгрөг,” Миний Монгол “цэцэрлэгт хүрээлэнд компанийн тарьж ургуулсан зүлэг модыг мэргэжлийн ажилчдаар арчилж тордуулахад 480 мянган төгрөг зарцуулсан байна.
- Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлд анхаарч тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг 2

удаа хүлээн авч санал хүсэлтийг нь сонсож ,хүндэтгэл үзүүлэн уулзалт зохион 1.2 сая төгрөг зарцуулжээ.

- Ажилчдын хүүхдүүдийн сургалтын төлбөр,түлээ нүүрс худалдан авах, эмнэлэгт үзүүлэх,эмчлүүлэх зэрэгт 597.5 мянган төгрөг , Эх үрсийн баяраар ажилчдын хүүхдүүдэд зориулж 268,9 мянган төгрөгний бэлэг, авьяаслаг хүүхдүүдэд аймаг, улсын чанартай тэмцээн уралдаанд оролцоход 300,0 мянган төгрөгний хандив тусламжийг тус тус олгожээ.
- Спорт бүх нийтийн үйл арга хэмжээний хүрээнд Монголын чөлөөт бөхийн шигшээ багийн тамирчин Өнөрбатыг сүүлийн 3 жил компаниас цалинжуулж,бэлтгэл сургуулалтыг хийлгэж байна.
- Компанийн эрүүл ахуйч эмч Баянмөнхийн санаачлагыг дэмжин тус захад тэрэг түрж ачаа зөөдөг түрээслэгч Б.Ганзоригт амьдрах орон сууц барих ажилд дэмжлэг үзүүлэн зүүд биш байгаадаа нэвтрүүлэгт оролцон олон түмнийг сайн үйлсэд уриалах ажилд идэвхитэй оролцлоо.
- Шинэ зах байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээнд 1500 орчим түрээслэгчдэд бэлэг дурсгалын зүйл, мэндчилгээ ,10 жилийн арван азтай түрээслэгчийг шалгаруулан 10 нөтбүүкээр урамшуулан нийтдээ 26.7 сая төгрөг зарцууллаа.

2009 онд “Дархан тээвэр” ХК нь ХАОАТатварт 9.2 сая,НДШ-д 34.6 сая,ААНОАТ-т 23.0сая ,НӨАТ-т59.4 сая,Бусад татварт 4.1 сая , бүгд 130.3 сая төгрөгийг аймаг улсын төсөвт төлсөн байна.

ТҮЗ-өөс нэгж хувьцаанд 100 төгрөгийн ноогдол ашиг олгож ,үлдэгдэл ашгийг ажлын байр шинээр бий болгох, орлого нэмэгдүүлэхэд зориулж хөрөнгө оруулалт хийх санал оруулж байна.

#### **2010 онд тавих зорилго, үйл ажиллагааны чиг хандлага**

1. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засгийн үзүүлэлтийг ханган биелүүлэх
2. “Дарханы Зах” худалдаа үйлчилгээний төвийг ашиглалтанд оруулж ажлын байр шинээр бий болгож орлого нэмэгдүүлэх

Та бүхнийг компанийн цаашдын үйл ажиллагааны чиглэлд үнэтэй санал зөвөлгөө өгч дэмжин ажиллана гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ж.Очирсүх

## **“Дархан Тээвэр”ХК-ний Хянан Шалгах Зөвлөлийн тайлан**

Дархан Тээвэр”ХК нь 2008 огоос хувьцаа эзэмшигчдийн хурлаараа “Алтан Сагс”ХХК-ний үйл ажиллагаа явуулж байсан Шинэ захын үйлчилгээг шилжүүлэн авч ХК-ний хэлбэрээр үйл ажиллагаа явуулсан байна.

Тус компани нь 248.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 497.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй нийт 745.4 сая төгрөгийн хөрөнгөтэй Дархан Уул аймгийн ард иргэдэд үйлчилж байна.

Санхүүгийн жилд нийт 961.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 236.4 сая төгрөгөөр илүү байна.

Бусдаас авах авлага 24.9 сая төгрөг болж өмнөх оноос 19.9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.

### **1. Хувь нийлүүлэгчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар:**

Тус компани нь хуулийн хугацаанд хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан хуралдуулж хурлаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад /Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Төлбөр Тооцооны Төвлөрсөн Хадгаламжийн төв/ хүргүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өмнөх хурлаар хяналтын зөвлөлөөс санал болгосон компаний нэрийг компаний явуулж байгаа үйл ажиллагаатайгаа уялдуулан өөрчлөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах талаар анхаарал тавин ажилласангүй гэж үзэж байна.

### **2. Компаний санхүүгийн үйл ажиллагааны талаар:**

Тус компаний нь 2009 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд гаргаж хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулж холбогдох газруудад хүргүүлэн ажилласан байна. Авлага тодорхой хэмжээгээр буурсан, богино хугацаат өглөг буурсан, борлуулалтын орлого болон ашгийн хэмжээ өссөн сайн үзүүлэлттэй байна.

Компаний 2009 оны үр дүнгээр 253.9 сая төгрөг болж өмнөх оноос 167.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Компани нь ХК-ний хэлбэрээр шинэчлэн зохион байгуулагдаж анхны жилдээ сайн ажилласан байна.

Компаний үйл ажиллагааны болон удирдлагын талаар хувь нийлүүлэгчид болон ажиллагсадаас ХШЗ-д ямар нэгэн гомдол санал ирээгүй болно.

### **Цаашид анхаарах асуудлууд**

- Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- Компаний бизнесийн хүрээг өргөтгөх санал санаачлагыг дэмжин эдийн засгийн хямралыг даван туулах бэлтгэлтэй байх
- Компаний Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид авах арга хэмжээг төлөвлөх
- Компаний нэрийг явуулж байгаа үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж өөрчлөх асуудлыг хувь нийлүүлэгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх
- Компаний үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэх, эд хөрөнгийн эрхийг гэрчилгээжүүлэх асуудлыг компаний ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх

### **Дүгнэлт**

**Компаний ХШЗ-өөс компаний ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг 2009 онд ажлаа хэвийн ,хуулийн хүрээнд сайн гүйцэтгэсэн байна гэж дүгнэж байна.**

**Анхаарал тавьсанд баярлалаа.**

**Хянан Шалгах Зөвлөлийн дарга:Б.Дэмид-Очир**

Бүх гишүүдийн 2010 оны 04 сарын 26-ны  
өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

“Дархан Тээвэр” ХК-ний 2009 оны  
Санхүүгийн ажлын тайлан

Компанийн 2009 оны бизнесийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулъя.

Хөрөнгө

2009 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр компаний нийт хөрөнгийн дүн 745.4 сая төгрөг байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө 497.0 сая төгрөг буюу 66.7%-ийг, эргэлтийн бус хөрөнгө 248.4 сая төгрөг буюу 33.3%-ийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгөнд шинээр ашиглалтанд оруулж буй худалдааны төвийн дуусаагүй барилгын 408.9 сая төгрөгний зардал байгаа ба нийт хөрөнгийн 54.8 % ийг эзэлж байгаа болно.

Орлого

Тайлангийн жилд компаний үйл ажиллагааны мөнгөн эх үүсвэр нь Шинэ зах, Буян зах, Шинэ орчин төвийн түрээсийн орлогуудаас бүрдэж байна.

Орлогын бүтэц.

д/д	Үзүүлэлт	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Дүн	
						Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Шинэ зах	184.4	158.6	169.4	183.9	603.2	696.3
2	Буян зах	28.1	25.6	27.0	25.1	94.5	105.8
3	Шинэ орчин	40.6	35.3	40.3	43.1	128.1	159.3
4	Дүн	253.1	219.5	236.7	252.1	825.8	961.4

2009 оны бизнес төлөвлөгөөнд эдийн засгийн хямралт байдлаас үүдэн орлогыг өмнөх оныхоос 20% -р буурна гэж үзэн 825.8 сая төгрөгөөр төлөвлөсөн. Иргэдийн худалдан авах чадвар, түрээслэгчдийн орлого буурсантай холбогдуулж түрээсийн төлбөрийг 4 сард 20% , 5,6,7 сард 15% бууруулан 54.8 сая төгрөг хөнгөлөлт үзүүлсэн.

Энэ хөнгөлөлт нь 2009 оны сүүлийн хагас жилд түрээслэгчдийн тоог бууруулахгүй байх, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого байсан бөгөөд үр дүнд нь 2009 оны орлогын төлөвлөгөө 16.4 % -р буюу 135.6 сая төгрөгөөр давж биеллэсэн.

Зарлага

Тайлант жилд 671.2 сая төгрөгийн зардалтай ажилласан байна. Компаний зардлыг гол нэр төрлөөр нь авч үзье.

д/д	Зардлын төрөл	ЗАА	Шинэ зах	Буян зах	Шинэ орчин	Дүн	Зардалд эзлэх хувь
1	1	2	3	4	5	6	7
2	Үндсэн цалин	37.2	81.7	21.2	22.4	162.5	24.2
3	НДШ	4.4	8.9	2.1	2.5	17.9	2.7
4	Цахилгаан		22.1	7.9	10.3	40.3	6.0
5	Дулаан		16.8	6.9	11.5	35.2	5.2
6	Цэвэр ус		10.9	1.9	4.6	17.4	2.5
7	Шуудан холбоо	8.0	0.6	0.5	0.5	9.6	1.4
8	Шатахуун	10.1	4.5	2.5	2.2	19.3	2.9
9	Сургалт		55.1			55.1	8.2
10	Урсгал засвар	0.2	46.9	2.9	1.9	51.9	7.7
11	Сэлбэг	3.8	16.2	9.4	5.2	34.6	5.2
12	Хангамж, барилгын материал	5.1	66.7	7.3	2.0	81.1	12.1
13	Хог тээвэрлэлт, тээврийн зардал		3.1	1.5	1.5	6.1	0.9
14	Гэрээт ажлын хөлс		12.7			12.7	1.9
15	Бичиг хэрэг, маягт		2.7			2.7	
16	ҮХЭХШ	10.3	2.9	2.5	3.6	19.3	2.9
17	Зар сурталчилгаа	2.9	23.8			26.7	4.0
18	Газрын төлбөр		1.3	0.6	1.5	3.4	0.5
19	Түрээсийн төлбөр		3.5			3.5	0.5
20	Албан томилолт	3.7				3.7	0.5
21	Хамгаалалт		29.0	11.5	4.8	45.3	6.7
22	Бусад	10.4	11.5	1.0		22.9	3.4
23	Үйл ажиллагааны нийт зардал	96.1	420.9	79.7	74.5	<b>671.2</b>	100.0

2009 оны зардлын хэмжээ 2008 оны зардлаас 162.1 сая төгрөгөөр бага байгаа ба нийт зардлын 25% ийг эзэлж буй засвар үйлчилгээний зардал бага гарсантай холбоотой байна. 2009 оны засвар үйлчилгээний зардалд шинэ захын зам талбайн засвар 12.6 сая төгрөг, барааны заалны дээврийн засварт 19.9 сая төгрөг, хөргүүр болон пүүний өрөөний засварт 4.7 сая төгрөг, бохирын труба сольсон 5.1 сая төгрөг тус тус зарцуулсан. Үүнээс харахад захын үйл ажиллагааг хэвийн явуулахад гарсан засвар үйлчилгээний зардал нийт зардлын 1/4ийг эзэлж байна.

#### Ашиг

Тайлант жилд 497.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж 961.4 сая төгрөгийн орлоготой 671.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч 253.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна .

#### Дансны авлага

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.	Байгууллага	37.2	19.5
2.	Хувь хүн	3.2	0.8
3.	Ажилчид	4.4	4.5
4.	Дүн	<b>44.8</b>	<b>24.8</b>

2008 оны эцсийн үлдэгдэл болох 35.3 сая төгрөгийн авлага найдваргүй, эзэн холбогдогч нь тодорхой бус авлагыг 2009 оны 03 сарын 20 ний өдрийн ТУЗХурлын № 03 тогтоолыг үндэслэн хасалт хийсэн. Үүнээс 2009 оны эцсийн үлдэгдэл болж буй 24.8 сая төгрөгийн авлага нь тодорхой хугацаатай, хувь хүн болон ажилчдын амжиргаанд зориулагдсан түр зээл хэлбэрээр байна.

#### Дансны өглөг

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.	Байгууллага	135.1	21.3
2.	Хувь хүн	85.0	10.3
3.	Ажилчид	5.3	62.6
4.	Татварын өглөг	10.1	20.8
5.	НДШ-ийн өглөг	3.7	2.2
6.	Бусад	3.7	5.2
7.	Дүн	<b>242.9</b>	<b>122.4</b>

2009 оны байдлаар бусдад өгөх өглөг буурсан.

#### Дүгнэлт

Санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн “Интерактив 4.0” программыг нэвтрүүлэн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн хөндлөнгийн хяналтыг “Итгэлт Аудит” ХХК-тай гэрээ байгуулан, улирал бүрийн тайлан балансад дүгнэлт гаргуулан, зөвлөгөө авч ажилладаг бөгөөд өгсөн зөвлөмж дүгнэлтийг мөрдлөг болгон ажиллаж байна. “Итгэлт Аудит” ХХК мэргэжлийн зөвлөмжөөр сайн ханган ажиллаж байгаа.

Тайлант жилд НӨАТ-т 59.4 сая төгрөг, ААН-ийн ОАТ-т 23.0 сая төгрөг, ХАОАТ-т 9.2 сая төгрөг, газрын төлбөр болон бусад татварын тооцоонд 4.1 сая төгрөг, НДШ-д 34.6 сая төгрөг нийт 130.3 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

2008 оны ногдол ашиг 81.7 сая төгрөг олгохоос Монгол Алт ХК-д 41.7 сая, Очирсүх 2.0 сая, Болортуяа 3.9 сая төгрөг олгосон ба 2009 оны жилийн эцэст 34.1 сая ногдол ашгийн өглөгтэй байгаа.

Цаашид компаний орлогыг нэмэгдүүлж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулан ашигласанаар компаний хувьцаа эзэмшигчдэд ногдох ашгийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллах болно.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ерөнхий ня-бо  Д.Бямбажаргал

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны  
 \_\_\_дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Дархан Уул аймгийн Дархан сумын  
 “Дархан Тээвэр”ХК-ний санхүү, аж ахуйн үйл  
 ажиллагааны 2009 оны жилийн тайлан тэнцлийн  
 хураангуй үзүүлэлт дараах байдалтай байгааг мэдээлж байна.

/мян.төгрөгөөр/

Балансын зүйл	Үлдэгдэл		Балансын зүйл	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн		Эхний	Эцсийн
А.Хөрөнгө	Х	Х	Б.Өр төлбөр ба эзэмшигчийн хөрөнгө	Х	Х
1.Эргэлтийн хөрөнгийн дүн	555.136.6	497.010.8	1.Өр төлбөрийн дүн	242.907.5	122.375.9
Мөнгөн хөрөнгө	7.370.2	32.964.9	Богино хугацаатай өр, төлбөр	242.907.5	122.375.9
Богино хугацаатай хөрөнгө оруулалт	2.500.0	2.500.0	Урт хугацаатай өр төлбөр		
Авлага	44.855.5	24.874.6	үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр		
Бараа бэлэн бүтээгдэхүүн	55.525.5	27.799.6	2.Өмчийн дүн		
Үндсэн ба туслах материал			Төрийн		
Урьдчилж төлсөн тооцоо	444.885.4	408.871.7	Хувийн		
Бусад			3.Хувьцааны дүн		
2.биет хөрөнгийн дүн	260.799.5	247739.6	Энгийн хувьцааны тоо ширхэг 163349 Нэрлэсэн үнэ 100	16334.9	16334.9
Газар			Давуу эрхтэй хувьцааны тоо,ширхэг..... нэрлэсэн үнэ.....		
Барилга байгууламж	207927.4	200.738.1	Халаасны хувьцааны үнэ		
Машин тоног төхөөрөмж	125854.5	123231.9	4.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	74.964.1	
Тавилга эд хогшил	19413.9	23.058.4	5.Хуримтлагдсан ашиг	396130.2	352699.7
Хуримтлагдсан элэгдэл	92396.3	99288.8	Тайлант үеийн ашиг	86.829.4	253.959.9
Бусад			6.Эзэмшигчдийн өмчийн дүн	574.258.6	622.994.5
3.биет бус хөрөнгийн дүн			Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	817.166.1	745.370.4
Лиценз	1.230.0	620.0			
4.Урт хугацаатай хөрөнгө оруулалт					
Нийт хөрөнгийн дүн	817.166.1	745.370.4			

Ерөнхий нягтлан бодогч



Д.Бямбажаргал

“Дархан Тээвэр” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцогчдоос  
санал авах хуудас

Хувьцаа эзэмшигч..... *Минхт* ..... ОВОГТОЙ ..... *Оюун* .....  
Регистрийн дугаар... *ТН 57070122* .....  
Дансны дугаар.....  
Бүртгэлийн дугаар.....

Эзэмшиж байгаа хувьцааны төрөл	1. Энгийн	<i>24518</i>
	2. Давуу эрхийн	
Кумулятив аргаар санал өгөх саналын тоо		<i>24518</i>

Санамж: Хэлэлцэх асуудалд санал өгөхдөө өөрийн саналыг /+/ тэмдгээр **зөвхөн тосон** балаар тэмдэглэнэ үү. Саналын хуудсыг балласан, засварласан тохиолдолд хүчингүйд тооцно.

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Онц	Сайн	Дунд
1.	<i>ТҮЗ-ийн тайлан</i>		+	
2.	<i>ХМЗ-ийн тайлан</i>		+	
3.	<i>Санхүүгийн тайлан</i>		+	
4.	<i>Ажлаас аж. болгох нэр солих.</i>		+	

Нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн санал

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	100	150	200
1.	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг		<i>300</i>	

Хуралд оролцогчийн гарын үсэг..... *М.Оюун* .....  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:  
Тооллогын комиссын дарга..... *М.Минхт* .....  
Хүчингүйд тооцсон шалтгаан.....



2010 оны 04 сарын 26-ны өдөр

**“Дархан Тээвэр” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцогчдоос санал авах хуудас**

Хувьцаа эзэмшигч..... *Мянган* ..... ОВОГТОЙ *Монхтор* .....  
 Регистрийн дугаар *ТЭ 57060916* .....  
 Дансны дугаар.....  
 Бүртгэлийн дугаар.....

Эзэмшиж байгаа хувьцааны төрөл	1. Энгийн	<i>114911</i>
	2. Давуу эрхийн	
Кумулятив аргаар санал өгөх саналын тоо		<i>114911</i>

Санамж: Хэлэлцэх асуудалд санал өгөхдөө өөрийн саналыг /+/ тэмдгээр **зөвхөн тосон** балаар тэмдэглэнэ үү. Саналын хуудсыг балласан, засварласан тохиолдолд хүчингүйд тооцно.

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Онц	Сайн	Дунд
1.	<i>ТУЗ-ийн тиймэн</i>		+	
2.	<i>ХЧЗ-ийн тиймэн</i>		+	
3.	<i>Санхүүгийн тиймэн</i>		+	
4.	<i>"Мянган" ХК болгох</i>		-	

Нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн санал

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	100	150	200
1.	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг		<i>300.</i>	

Хуралд оролцогчийн гарын үсэг..... *Монхтор* .....  
 Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:  
 Тооллогын комиссын дарга..... *М. Мунхтор* .....  
 Хүчингүйд тооцсон шалтгаан..... *ХК* .....



2010 оны 04 сарын 26-ны өдөр

**“Дархан Тээвэр” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцогчдоос  
санал авах хуудас**

Хувьцаа эзэмшигч Найбал овогтой Очирух  
 Регистрийн дугаар 76 63082579  
 Дансны дугаар 15 - 190055  
 Бүртгэлийн дугаар .....

Эзэмшиж байгаа хувьцааны төрөл	1. Энгийн	9523
	2. Давуу эрхийн	
Кумулятив аргаар санал өгөх саналын тоо		9523

Санамж: Хэлэлцэх асуудалд санал өгөхдөө өөрийн саналыг /+/ тэмдгээр зөвхөн тосон балаар тэмдэглэнэ үү. Саналын хуудсыг балласан, засварласан тохиолдолд хүчингүйд тооцно.

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Онц	Сайн	Дунд
1.	ГУУШ-ийн тайлан		+	
2.	ХМЗ-ийн тайлан		+	
3.	Санхүүгийн тайлан		+	
4.	ХК-ийн нэрийг өөрчлөх "Алтан Сагс" бөмбөг		+	

Нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн санал

Д.д	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	100	150	200
1.	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг		320.	

Хуралд оролцогчийн гарын үсэг..... /  
 Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:  
 Тооллогын комиссын дарга..... /  
 Хүчингүйд тооцсон шалтгаан..... ХК..... /



2010 оны 04 сарын 26-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн 2010 оны бүх гишүүдийн хурлын саналыг хуудас тоолсон  
тооллогын комиссын актын хавсралт

№	Төлөөлөн удирдах зөвлөл				Хянан шалгах зөвлөл				Санхүүгийн тайлан			
	Онц	Сайн	Дунд	Бүгд	Онц	Сайн	Дунд	Бүгд	Онц	Сайн	Дунд	Бүгд
1		114911		114911		114911		114911		114911		114911
2		9583		9583		9583		9583		9583		9583
3		24518		24518		24518		24518		24518		24518
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>149012</b>	<b>0</b>	<b>149012</b>	<b>0</b>	<b>149012</b>	<b>0</b>	<b>149012</b>	<b>0</b>	<b>149012</b>	<b>0</b>	<b>149012</b>

Тооллогын комиссын дарга.....*Ж.Мягмаа* Ж.Мягмаа  
Гишүүн .....*Э.Золзаяа* Э.Золзаяа



